/БОНХЯ-ны 2014 оны А-04 тушаалаар хүчингүй болсон/

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ / Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам/ 2007 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улаанбаатар хот Дугаар 6 “Ашигт малтмалын тухай” Монгол Улсын хуулийн 39 дүгээр зүйлийн 8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь: 1.“Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг хавсралтын ёсоор батлалсугай. 2.Энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Ц.Банзрагч/-т үүрэг болгосугай.

САЙД И.ЭРДЭНЭБААТАР Улсын бүртгэлийн 2007 оны 2687 дугаарт бүртгэсэн